



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 1 дүгээр  
сарын 24-ний өдөр

Дугаар 21


Улаанбаатар  
хот

Газрын тос боловсруулах үйлдвэр барих  
төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын  
талаар авах арга хэмжээний тухай

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Төмөр замын тээврийн тухай хуулийн 6.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.4, Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдөр соёрхон баталсан “Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн ерөнхий хэлэлцээр”, Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”-ийн 8.2.9-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын хүрээнд хийгдэх “Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр” чиглэлийн төмөр замын салбар зам, хүнд даацын тусгай зориулалттай авто зам, цахилгаан дамжуулах сүлжээ барих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил болон барилгын ажлыг гүйцэтгэгчийг тухайн ажлыг гүйцэтгэх туршлага болон техник, тоног төхөөрөмжийн чадавхтай төрийн өмчит хуулийн этгээдүүдээс сонгон хэрэгжүүлэхийг Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн нарт даалгасугай.

2. Төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга

У.ХҮРЭЛСҮХ

Г.ЗАНДАНШАТАР